



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 5 сарын 10 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч
/брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 9 компанийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/, энэхүү тогтоолын хавсралтад заасан компанийн гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.

1/ Харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх;

3/ Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст тогтмол төвлөрүүлж ажиллах;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн
96 дугаар тогтоолын хавсралт



Д/д	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэр	Регистрийн дугаар	Гүйцэтгэх захирлын нэр
1.	“Хаан тэлмэн ХААБ” ХХК	5349508	О.Батсүлд
2.	“Ханбүргэд Хэнтий ХААБ” ХХК	2842289	Ч.Амгаланбаатар
3.	“Бадархундага оргил ХААБ” ХХК	3496678	М.Баярмагнай
4.	“Цэц инвест ХААБ” ХХК	5680727	Л.Уянгахүү
5.	“Баяр плант ХААБ” ХХК	5569818	Б.Бямбасэлэм
6.	“Танан дээж трейд ХААБ” ХХК	5685192	О.Оюун-Эрдэнэ
7.	“МЭТУ ХААБ” ХХК	5680697	З.Эрдэнэхуяг
8.	“Увс таван эрдэнийн ундарга ХААБ” ХХК	4010671	Л.Арцанхүү
9.	“Ивээлт инэл” ХХК	5692857	Б.Бүрнээбаатар